

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

САНАМЖ:

I. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.

II. Сонгох даалгавраас зөвхөн нэг хариуг сонгоорой.


1. Дэлхийн хэлбэр хэмжээг багасган үзүүлсэн бодит загварыг сонгоно уу. /1 оноо/

A. Глобус B. Газарзүйн зураг C. Гэрэл зураг
D. Атлас E. Агаарын зураг

2. Наранд хамгийн ойр орших гараг аль нь вэ? /1 оноо/

A. Бархасбадь B. Дэлхий C. Буд D. Ангараг E. Тэнгэрийн ван

3. Хүний хөгжлийн индекс (ХХИ)-ийн үзүүлэлтэд асуултын тэмдгийн оронд тохирох хариултыг сонгоно уу. /1 оноо/



A. Тогтвортой хөгжил B. Хүн амын өсөлт C. Ажиллах хүч
D. Дундаж наслалт E. Амьдралын түвшин

4. 2022 оны эхний хагаст ОХУ, Украин улсын дайны улмаас Украины 11 сая орчим хүн Европын улс орон руу дүрвэн суурьшсан нь шилжих хөдөлгөөний ямар хэлбэр вэ? /1 оноо/

A. Түр зуурын шилжих хөдөлгөөн B. Гадаад шилжих хөдөлгөөн
C. Сайн дурын шилжих хөдөлгөөн D. Дотоод шилжих хөдөлгөөн
E. Албадлагын шилжих хөдөлгөөн

5. Хотжилтын түвшин хамгийн өндөр улс аль нь вэ? /1 оноо/

A. Аргентин B. Франц C. Энэтхэг D. Бельги E. Индонез

6. Аж үйлдвэрийг байршуулахад нөлөөлөх байгалийн хүчин зүйлийг сонгоно уу. /1 оноо/

A. Зам тээвэр B. Зах зээл C. Түүхий эд
D. Ажиллах хүч E. Амьдралын чанар

7. Бөхөн байгалийн аль бүсэд амьдардаг вэ? /1 оноо/

A. Хүйтэн бүс B. Сэрүүн бүс C. Субтропикийн бүс
D. Тропикийн бүс E. Экваторын бүс

8. Магмын чулуулаг аль нь вэ? /1 оноо/


A. Шохойн чулуу B. Гантиг C. Шаварлаг занар
D. Галт уулын шил E. Хөрзөн чулуу

9. Агаарын ижил даралттай цэгүүдийг холбосон шугамыггэнэ. /1 оноо/

A. Изобар B. Изокол C. Изотерм D. Изогипс E. Изобат

10. Далайн урсгалын зурагт 1-ийн тоогоор тэмдэглэсэн урсгалыг нэрлэнэ үү.

/1 оноо/




А. Гольфстримын урсгал
D. Куросиогийн урсгал

В. Аляскийн урсгал
Е. Бразилийн урсгал

С. Саргассын урсгал

11. Биомасс хаана хамгийн бага байна вэ?

/1 оноо/



А. Субтропикийн ой

В. Цөл

С. Хээр


Д. Тундр

Е. Мөс

12. Газарзүйн зургийг хамрах нутгаар нь ангилдаг. Тивийн зургийг сонгоно уу.

/1 оноо/

А.



В.



С.



Д.



Е.



13. Зургийг ажиглан зөв тодорхойлсон хариултыг сонгоно уу.

/1 оноо/



A. Вектор зураг
D. Растер зураг

B. Сансрын зураг
E. Аялалын зураг

C. Агаарын зураг

14. Нарны аймгийн алслагдсан дарааллаар 4 дүгээрт байрлах, тэнхлэгээ эргэх хугацаа нь 24 цаг 7 минут 23 секунд бөгөөд 687 хоногт нарыг 1 бүтэн тойрдог, сайн судлагдаж буй гарагийг олно уу.

/1 оноо/

A. Сугар

B. Дэлхий

C. Бархасбадь

D. Ангараг

E. Санчир

15. Хурдтай хөгжиж буй олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, ТВ, интернет, харилцаа холбооны болон орчин үеийн тээврийн хэрэгсэл, хөгжлийн хувьд нэгдэж буй үйл явцыг илэрхийлсэн даяаршлын хүрээг тодорхойлно уу.

/1 оноо/

A. Ардчилалын даяаршил

B. Улс төрийн даяаршил


C. Нийгмийн даяаршил

D. Эдийн засгийн даяаршил

E. Соёлын даяаршил

16. Тоон үзүүлэлтийг ашиглан орхигдсон бүс нутгийн хүн амын эзлэх хувийг тодорхойлно уу.

/2 оноо/



A. 13.5%

B. 12.5%


C. 14.5%

D. 15.5%

E. 11.5%

17. 2017 оны Катар улсын хүн амын суваргыг ашиглан зөв тайлбарласан хариуг олоорой.

/1 оноо/



- A. 60-с дээш насны эрэгтэйчүүдийн тоо цөөн
- B. 10-29 насны эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн тоо ойролцоо
- C. 50-59 насны эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдээс олон
- D. 40-49 насны эмэгтэйчүүдээс эрэгтэйчүүдийн тоо олон
- E. 0-9 насны эрэгтэй хүүхдийн тоо эмэгтэйгээсээ цөөн


18. Органик фермийн тариалангийн талбайн хэмжээгээр тэргүүлэгч Америк тивийн орнуудыг сонгоно уу.

/1 оноо/

- A. Канад, Перу B. Уругвай, Бразил C. Аргентин, АНУ
- D. АНУ, Боливи E. Аргентин, Чили

19. Хуурай газарт тээврийн сүлжээг өргөжүүлэхэд тулгардаг сааднуудын нэг нь холбосон авто зам барих нь.....хүчин зүйл юм.

/1 оноо/



- A. Нуур ба гол мөрөнг, харьцангуй
- B. Уул ба хөндийг, харьцангуй
- C. Уул ба хөндийг, үнэмлэхүй
- D. Тэнгис ба буланг, үнэмлэхүй
- E. Шавар ба намгийг, харьцангуй

20. Газарзүйн бүрхэвчийн бүс, бүслүүрлэг шинж чанарын онцлогийг зөв тодорхойлсон хариултыг олно уу.

/2 оноо/


- A. Галт уулын дэлбэрэлтээс хий, тоос нэмэгдэх B. Тектоникийн хөдөлгөөн эрчимжих
- C. Агаарт чийг өтгөрч үүл бүрэлдэх D. Хөрс, ургамал, амьтан тархах
- E. Өдөр шөнө ээлжлэх, улирал солигдох

21. Голдуу үйлдвэр ихтэй том хотын дээр үүсдэг, агаарт нүүрсхүчлийн хий болон хатуу хольцууд ихэссэнээс болж газрын гадаргаас ялгарах дулааныг тогтоон барьж буй үзэгдэл инверсийн ямар төрөл вэ?

/1 оноо/

- A. Адвекцийн инверс B. Хаврын инверс C. Цацрагийн инверс
- D. Уулзүйн инверс E. Агаарын бохирдлын инверс

22. Хойд Америкийн Сьерра Невада уул нь д.т.д 4418 м өндөр бөгөөд энэ нь уулын ямар төрөлд хамаарагдах вэ? /1 оноо/



- A. Атираат уул
- B. Галт уул
- C. Хөмбөн уул
- D. Зөрөгт уул
- E. Өндөр уул

23. Гадаргын хэлбэрт нөлөөлсөн гол хүчин зүйлийг тодорхойлно уу.


/1 оноо/



- A. Мөсөн голын нөлөө
- B. Усны нөлөө
- C. Нарны энергийн нөлөө
- D. Галт уулын нөлөө
- E. Салхины нөлөө


24. ОХУ-ын Иркутск хотод хэддүгээр саруудад хамгийн их тунадас унадаг вэ?

/2 оноо/




- A. IV - V сард
- B. V - VI сард
- C. VI – VII сард
- D. VIII - IX сард
- E. VII - VIII сард

25. Тойргон диаграммаар далайн усны бохирдлын хувийг харуулав. Хамгийн их бохирдуулж байгаа эх үүсвэрийг сонгоно уу. /1 оноо/




- A. Эрэг орчмын уул уурхай
B. Хөлөг онгоц
C. Хог хаягдал
D. Агаарын бохирдол
E. Цутгал гол

26. Гималайн нуруунд д.т.д 8848 м өндөрт биомассын тархалтад тохирох экосистем аль нь байна вэ? /1 оноо/




- A. Өвстэй тал
B. Тундр ба таг
C. Нуга намаг
D. Чулуу ба мөс
E. Жинхэнэ цөл

27. Ургамал ургахад шаардагдах органик бодисын хэмжээг хөрсний үржил шим гэнэ. Хамгийн үржил шимт хөрсийг сонгоно уу. /1 оноо/



28. Сурагч Туяа найзын хамт модон гүүрээр гарч голын зүүн эргээр хойд зүгт аялав. Аялалын төгсгөлд ямар объект таарах вэ? /2 оноо/



- A. Сайжруулсан шороон зам
B. Гуу жалга
C. Бут ба ой
D. Усан цахилгаан станц
E. Жимсний цэцэрлэг

29. “Google Map”-ын газарзүйн зургийг ашиглан Эрдмийн өргөө цогцолбор сургуулиас зүүн хойд зүгт байрлах объектыг нэрлэнэ үү. /2 оноо/



- A. 56-р сургууль
B. 114-р цэцэрлэг
C. Голомт банк
D. Хөл бөмбөгийн талбай
E. Прогресс зочид буудал


30. Улаанбаатар хотод өдрийн 13 цаг болж байв. Энэ үед Берлинд (I цагийн бүс) хэдэн цаг болж байх вэ? /2 оноо/

- A. 09 цаг
B. 08 цаг
C. 07 цаг
D. 13 цаг
E. 12 цаг


31. Өндөр технологийн ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлж байгаа үйл явцыг тодорхойлно уу. /2 оноо/

- A. Гэрийн мод, тавилга хийх
B. Нано бүрхүүлт гэрийн бүрээс үйлдвэрлэх
C. Арьс, шир элдэж сур бэлтгэх
D. Сүүг уламжлалт аргаар боловсруулах
E. Алтыг гар аргаар олборлох

32. Хүн амын ихэнх хувийг 30-60 насныхан эзэлдэг, дундаж наслалт өндөртэй, төрөлт буурснаас шалтгаалж хүн амзүйн хямралд орсон улсыг сонгоно уу. /2 оноо/



33. Иргэн Дорж хөдөөнөөс хот руу ирж сууршихдаа хамаатныхаа хашаанд амьдрахаар төлөвлөжээ. Энэ нь хот төлөвлөлтийн “Бага орлоготой иргэдийн хороолол”-д хамаарах тул секторлог загварын аль тоон утгад тохирох вэ? /2 оноо/



- A. 1
B. 5
C. 2
D. 3
E. 6

34. Өгөгдлийг уншаад эрчим хүчний гол эх үүсвэр нь байгалийн ямар нөхцлөөс шалтгаалсан болохыг тодорхойлно уу. /2 оноо/

Төв аймгийн “Салхит”-ын салхин станц нь жилдээ 168.5 сая кВт эрчим хүчийг үйлдвэрлэх чадалтай, 100.000 өрхийн хэрэглээг хангадаг. Жил бүр хүлэмжийн хийн ялгарлыг 180.000 тонноор бууруулахаас гадна 1.6 сая тонн цэвэр ус, 122.000 тонн нүүрс хэмнэдэг.

- A. Харьцангуй өндрийн зөрүү ихтэй уулархаг гадарга
B. Хөндий, хотгорын төвийн чийг намагтай гадарга
C. Салхины хурд тогтворгүй талархаг нам гадарга
D. Нарны тусгал болон ууршилт ихтэй ээвэр гадарга
E. Салхины хурд тогтвортой өндөрлөг гадарга

35. Тээврийн төрлүүдийг давуу талуудтай нь харгалзуулна уу.

/2 оноо/

№	Тээврийн төрлүүд		Давуу тал
1	Агаарын тээвэр	а	Их ачааг нэг дор тээвэрлэнэ, хямд өртөгтэй
2	Усан замын тээвэр	б	Цаг агаараас нөхцлөөс хамаарахгүй, хямд өртөгтэй
3	Авто замын тээвэр	в	Холын зайд хурдан, тав тухтай
4	Төмөр замын тээвэр	г	Богино зайд илүү дөт, хэрэглэгчдэд шууд хүрдэг

A. 1в,2а,3г,4б B. 1г,2б,3а,4в C. 1а,2г,3в,4б D. 1в,2б,3г,4а E. 1б,2а,3в,4г

36. Хэрэв чи Индонез улсын Жакарта хотод суралцахаар явж байгаа гэж төсөөлье. Тэнд газарзүйн бүсийн ямар орчинтой байх вэ? /2 оноо/


- A. 7-р сард $+10^{\circ}\text{C}$ хүрэхгүй, өвөлдөө -40°C , дунджаар 50-100 мм орчим тунадас унадаг. Дулаан дутагдалтай учир ууршилт бага, цэвдэг, намаг элбэг тархсан.
- B. Халуун хуурай, агаарын их даралтын мужид оршдог. Пассат салхи зонхилдог. Өвөл $+10^{\circ}\text{C}$ -ээс буурахгүй, зундаа дунджаар $+30^{\circ}\text{C}$ - $+35^{\circ}\text{C}$. Саванн, цөл, халуун орны ойтой.
- C. Баруун зүгийн салхины нөлөөнд оршино. Далайн эргээр чийглэг, эх газрын төв хэсгээр хуурай, тайга, хээр, цөл, холимог ойтой. 1-р сард -10°C орчим, 7-р сард $+25^{\circ}\text{C}$, дунджаар 180-200 мм орчим тунадас унадаг.
- D. Дулаан ба чийгийн хувьд улирлын ялгаа байхгүй. Чийглэг, мөнх ногоон ойтой, жилийн туршид $+25^{\circ}\text{C}$ - $+30^{\circ}\text{C}$, дунджаар 2000 мм түүнээс их тунадас унадаг.
- E. Хамгийн дулаан сардаа $+5^{\circ}\text{C}$ орчим түүнээс бага температуртай. Дээд ургамалгүй, хаг, хөвд ургана, үргэлжилсэн цэвдэгтэй, дунджаар 5-30 мм орчим тунадас унадаг.

37. Монгол Улс Парисын хэлэлцээрийг УИХ-аар хэлэлцэн 2016 онд соёрхон баталсан. Хүлэмжийн хийн ялгаруулалтаа бууруулахад хувь нэмрээ оруулах зорилгоор хийж буй үндсэн үйл ажиллагааг сонгоно уу. /2 оноо/

- A. Бэлчээрийн даацыг нэмэгдүүлэх
- B. Ойн санг багасгах
- C. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх
- D. Нүүрсхүчлийн хийг ихэсгэх
- E. Гадаргын усыг бохирдуулах

38. Хүн ам нь ундны усны хомсдолд орсон Африк тивийн улсуудыг олно уу.

/2 оноо/



А. Мозамбик, Колумб, Египет
С. Нигер, Судан, Афганистан
Е. Ангол, Кени, Иордан

В. Сомали, Чад, Нигери
D. Этиоп, Конго, Албани


39. Өмнөд Америкийн хавтан, Африкийн хавтангаас 1 жилд 4 см-ээр холдон салдаг бол 1 сая жилийн дараа хэдэн км-ийн зайтай холдохыг тооцоолно уу. /2 оноо/

А. 4000 км В. 4 км С. 400 км D. 40 км Е. 0.4 км

40. АНУ-ын Вашингтон хотод амьдардаг ахындаа урилгаар зочилсон Дулмаад өнөөдөр агаарын температур 95°F гэдгийг цельсийн хуваариар хэд гэж ойлгуулах вэ? $t^{\circ}\text{C} = 5/9(t^{\circ}\text{F} - 32)$ /2 оноо/

А. 30°C В. 32°C С. 36°C D. 34°C Е. 35°C

41. Хуурай газар ба усны харилцан адилгүй халж, хөрдөг зүй тогтлоос болж өдөр, шөнөөр чиглэлээ өөрчилдөг орон нутгийн салхины өдрийн чиглэлийг тодорхойлно уу. /2 оноо/



А. Нуураас эрэг рүү чиглэнэ В. Эргээс нуур луу чиглэнэ
С. Далайгаас эх газар луу чиглэнэ D. Эх газраас далай руу чиглэнэ
Е. Мэлхийн замаас экватор луу чиглэнэ

42. Орхон гол Хангай нурууны Суваргахайрхан уул (д.т.д 3021 м) -аас эх авч 1124 км урсаад Сэлэнгэ мөрөн (д.т.д 601 м) -д цутгадаг бол голын уналыг тооцоолно уу. $(H = H_1 - H_2)$ /2 оноо/

А. 3622 м В. 1897 м С. 1725 м D. 2420 м Е. 4145 м

43. Хээрийн бүсэд хүнсний ногоо тариалахад хамгийн тохиромжтой хөрсийг сонгоно уу. /2 оноо/

А. Цайвар саарал, Карбонат, шохой, давс их, 0.2-0.5% ялзмагт хөрс
В. Улаан хүрэн, Төмөр, хөнгөн цагааны исэл их, 3-5% ялзмагт хөрс
С. Хүрэн, Кальци, магниар баялаг, 5-7% ялзмагт хөрс
D. Цайвар бор, Сульфат, натриар баялаг, 2-3% ялзмагт хөрс
Е. Саарал, Цахиур, шүлтийн агууламж их, 1.5 – 2% ялзмагт хөрс

44. гараг нарнаас 58 сая км зайд алслагдсан байдаг. Энэ зайг одон орны нэгжээр илэрхийлнэ үү. /2 оноо/


А. Дэлхий, 92 о.о.н В. Буд, 0.39 о.о.н С. Сугар, 39 о.о.н
D. Буд, 2.58 о.о.н Е. Дэлхий, 1.00 о.о.н

45. Дунд зэргийн хөгжилтэй орнуудын хүн ам, бараа бүтээгдэхүүн, худалдааны хувь хэмжээг тодорхойлно уу. /2 оноо/

№	Үзүүлэлт	Хөгжингүй	Дунд зэргийн хөгжилтэй	Хөгжиж буй
1	Хүн ам	15%	?	80%
2	Бараа бүтээгдэхүүн	47%	?	21.4%
3	Худалдаа	51%	?	30%

- A. Хүн ам 95%, Бараа бүтээгдэхүүн 68.4%, Худалдаа 81%
 B. Хүн ам 5%, Бараа бүтээгдэхүүн 25.6%, Худалдаа 21%
 C. Хүн ам 65%, Бараа бүтээгдэхүүн 31.6%, Худалдаа 19%
 D. Хүн ам 5%, Бараа бүтээгдэхүүн 31.6%, Худалдаа 19%
 E. Хүн ам 5%, Бараа бүтээгдэхүүн 68.4%, Худалдаа 19%

46. Графикийг ашиглан сүүлийн 20 жилд хөдөөгийн хүн ам хэдэн хувиар буурах хандлагатай байгааг тооцоолно уу. /2 оноо/




- A. 89.3% B. 49.2% C. 40.1% D. 11.8% E. 9.1%

47. Дэлхийн уур амьсгалын зарим бүсүүдийн онцлогоос хамаарсан эрхлэх аж ахуйг харгалзуулна уу. /2 оноо/


№	Уур амьсгалын бүсүүд		Бүсүүдийн онцлог		Эрхлэх аж ахуй
1	Экваторын	А	Өвөл бага зэрэг хүйтэн, зун нь чийглэг халуун	а	Алим
2	Газар дундын тэнгисийн	Б	Өвөл хүйтэн, хавар, намар сэрүүн	б	Кофе
3	Эх газрын	В	Жилийн туршид халуун, чийглэг	в	Усан үзэм

- A. 1Б6, 2Ав, 3Ба B. 1А6, 2Бв, 3Ва C. 1Бв, 2Ва, 3Б6
 D. 1Ва, 2Бв, 3А6 E. 1Бв, 2Б6, 3Ба

48. Дэлхий дээрх хоёр цэгийн хоорондох хамгийн богино буюу дөт агаарын зам нь дэлхийн бөмбөрцгийн их тойргийн нумын дагуу тодорхойлогдоно. Токио хотоос Нью-Йорк хот руу шууд нислэг хийхэд аль зүг рүү хөөрвөл илүү дөт зам байх вэ? /2 оноо/



- A. Баруун өмнөд зүг рүү
B. Баруун хойд зүг рүү
C. Зүүн өмнөд зүг рүү
D. Зүүн хойд зүг рүү
E. Баруун зүг рүү
49. Гималай нурууны өвөрт орших Черрапунжид жилд 12000 мм тунадас унах бөгөөд уурших чадвар нь 1550 бол чийглэг байдлыг тооцоолно уу. ($K=r/E$. r -тунадасны нийлбэр, E -уурших чадвар) /2 оноо/
- A. 0.1
B. 0.7
C. 7.7
D. 0.8
E. 1.3
50. Монгол орны гадаргын усны нөөц хамгийн ихтэй аймаг болон хамаарах гол мөрдийн ай савыг зөв тодорхойлсон хариултыг сонгоно уу. /2 оноо/



- A. Завхан-Номхон далайн ай сав
B. Хөвсгөл-Хойд мөсөн далайн ай сав
C. Баянхонгор-Төв Азийн гадагш урсгалгүй ай сав
D. Дорнод-Номхон далайн ай сав
E. Архангай-Хойд мөсөн далайн ай сав

ХОЁРДУГААР ХЭСЭГ**САНАМЖ:**

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзаа /хариу, бодолт/-г зөв тогтоож, хариуг бөглөөрэй.
2. Хоёрдугаар хэсгийн бодлогын хариуг хариултын хуудасны хоёрдугаар хэсэгт доорх хэлбэрээр бөглөхийг анхаарна уу. Жишээлбэл: Бодлогын хариу 1234 гарсан гэж үзвэл a1 b2 c3 d4 гэж бөглөнө.
3. Хэрэв бодлогын хариу бутархай тоо байвал бодлого тус бүрийн хариултын загварын дагуу бөглөнө. Жишээлбэл: Бодлогын хариу 45.67 гарсан гэж үзвэл тухайн бодлогын хариулт бөглөх загварыг [ab.cd] гэсэн байдлаар өгсөн байна. Дээрх хариуг бөглөхдөө a4 b5 c6 d7 гэж бөглөнө.
4. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.


2.1. БУ45⁰ дээр орших А хотод ням гарагийн 21 цаг болж байв. Тэгвэл ЗУ90⁰ дээр орших Б хотод ямар гарагийн хэдэн цаг болж байхыг тооцоолно уу. **/6 оноо/**

А. Цагийг тооцох [a] /4 оноо/

В. Гараг нэрлэх [b] /2 оноо/

1. Лхагва 2. Даваа 3. Мягмар 4. Ням 5. Пүрэв

2.2. Графикийг ажиглан дараах асуултад хариулна уу. **/6 оноо/**



А. 2000-2010 оны хооронд Өмнөговь аймгийн хүн ам 1 жилд хэдээр өссөн бэ? [abc] /3 оноо/


В. Хүн ам хэдээс хэдэн оны хооронд хамгийн их өсөлттэй байсан бэ? [d] /3 оноо/

1. 1969-1979 он 2. 2010-2015 он 3. 1979-1990 он
4. 1990-2000 он 5. 2000-2010 он

2.3. Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутагт орших Шилийн Богд (д.т.д 1778 м) уулын бэлд (д.т.д 1278 м) агаарын температур $+20^{\circ}\text{C}$ байх үед уулын оройд хэдэн хэм байх вэ?

/6 оноо/

Агаарын температур 100 м өндөрсөх тутамд 0.6°C -ээр буурна.



А. Агаарын температур

[ab] $^{\circ}\text{C}$

/2 оноо/

В. Харьцангуй өндрийг бодож олоорой.

[cde] м

/2 оноо/

С. Хотгор гүдгэрийн хэв шинжийн аль ангилалд багтахыг сонгоно уу.

[f]

/2 оноо/

1. Өндөр уул

2. Дундаж өндөр уул

3. Нам уул

4. Цав толгод

5. Ухаа гүвээ

2.4. Далай, тэнгисийн тухай ойлголтуудыг зөв хариутай нь харгалзуулна уу.

[a], [b], [c], [d], [e], [f]

/6 оноо/

a	Далай, тэнгисийн усны түвшин тодорхой хугацаанд буурах үзэгдэл	1	Давсжилт
b	Хойд мөсөн далайг Номхон далайгаас тусгаарладаг хоолой	2	Гольфстрим
c	Далай тэнгисийн усан дахь давсны хэмжээ ба найрлага	3	Татралт
d	Хойд Атлантын далайн үндсэн гол урсгал	4	Тасман
e	Австрали болон Шинэ Зеланд улсуудын хооронд орших тэнгис	5	Гвиней
f	Африк тивийн баруун эрэгт экваторын шугам дагуу орших булан	6	Беринг
		7	Номхон